



MONNIS
MONNIS MOTORS



БИДНИЙ ТУХАЙ

Моннис Группийн ууган компани Моннис Моторс ХХК нь 90 гаруй жилийн түүхт Японы тэргүүлэгч автомашин үйлдвэрлэгчдийн нэг Ниссан Мотор компанийн Монгол Улс дахь албан ёсны төлөөлөгчөөр 1998 онд үйл ажиллагаагаа эхлүүлж одоо 90 гаруй ажилтантайгаар илүү өргөжин ажиллаж байна. ЯПОН, АНУ, ИХ БРИТАНИ, ТАЙЛАНД, ЭНЭТХЭГ орны НИССАН-ны үйлдвэрүүдээс автомашинаа захиалан авдаг ба ингэснээр 20 гаруй загварын НИССАН автомашинуудаас хэрэглэгч нартаа сонголт хийх боломжийг олгодог.

ТҮҮХЭН ЗАМНАЛ

- Моннис Группын ууган компани болох “Моннис Моторс” ХХК нь Япон улсын тэргүүлэгч автомашин үйлдвэрлэгчдийн нэг Ниссан Моторс компанийн Монгол улс дахь албан ёсны төлөөлөгчөөр 1998 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.
- Бид Ниссан брэндийн хамгийн сүүлийн үеийн цоо шинэ загварын автомашинуудыг Монголынхоо хэрэглэгчдэд цаг алдалгүйгээр хүргэдгээс гадна автомашин борлуулалтын дараах үйлчилгээ болох Ниссан оригинал сэлбэгийн худалдаа, баталгаат засвар үйлчилгээг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсээр ирсэн.
- Ниссан брэндийн автомашинууд нь загварынхаа онцлогоос шалтгаалж улс орон бүрд харилцан адилгүй өөр өөр үйлдвэрлэгддэг бөгөөд манай компанийн хувьд Япон, АНУ, Англи, Тайланд улс дахь үйлдвэрүүдээс 20 гаруй төрлийн Ниссан брэндийн автомашиныг захиалан импортолж байна.
- Бид 2006 онд олон улсын стандартын дагуу Монгол Улсад анхны автомашины үзүүлэнгийн танхим, засвар үйлчилгээний төвийг Сүхбаатар дүүрэгт барьж ашиглалтад оруулж байсан түүхтэй. Үүнээс хойш компанийн үйл ажиллагаагаа тэлж, хэрэглэгчдэдээ ойр байх зорилгоор 2012 онд Эрдэнэт хотод, 2013 онд Баянзүрх дүүрэгт, 2019 онд Сүхбаатар аймагт тус тус Ниссан засвар үйлчилгээний төвүүдийг нээж, үйл ажиллагаагаа явуулсаар байна.
- Манай компани Франц улсын Renault группийн албан ёсны дилерээр 2018 оноос эхлэн тасралтгүй хамтран ажиллаж байна.





MONNIS
MONNIS MOTORS



ҮНЭ ЦЭНЭТЭЙ БРЭНД

Бидэнд дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхах боломжийг бий болгож буй олон улсын стандарт, дэвшилтэт технологиороо монголын автомашины салбарт үнэтэй хувь нэмэр оруулагч БРЭНД нь бидний үнэт зүйл юм.



АЛСЫН ХАРАА

Ажилтан бүрийн амьдралын баталгаа, ажиллах таатай орчныг бий болгож, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан, улс эх орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулагч КОМПАНИ нь бидний үнэт зүйл юм.



ХАРИЛЦАГЧ ТӨВТЭЙ

ХАРИЛЦАГЧ та манай компанийн эрхэм хамтрагч бөгөөд таны сэтгэл ханамж бидний амжилтын үндэс юм. Бидний үйл ажиллагааны зорилго бол харилцагчийн хүндлэлийг хүлээхэд оршино.





MONNIS
MONNIS MOTORS

БАТАЛГААТ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

Сервис нь Сүхбаатар дүүргийн 2р хороонд байрлах Ниссан -Рено төвд байрлахаас гадна Баянзүрх дүүргийн Амгалан салбаруудад нийт 80 орчим инженер, техникийн ажиллагсад Ниссан Реногийн сүүлийн үеийн компьютер оношлоогоо , тэнхлэг тохиргооны аппарат, олон улсын стандартыг хангасан техник багаж хэрэгсэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

ОРИГНАЛ СЭЛБЭГ

Сэлбэгийн худалдааны хэлтэс нь Ниссан-Рено автомашины бүх төрлийн оригинал сэлбэг, дугуй, нэмэлт тоноглол, бүх төрлийн тосыг АНУ, ЯПОН, ОРОС, ФИНЛЯНД-аас оруулж ирэн үйлчлүүлэгчдээ хүргэж байна.Хэрэв манай төвд тухайн сэлбэг байхгүй тохиолдолд дээрх орнуудаас 14-30 хоногийн дотор захиалан нийлүүлдэг.



Манай хамт олон Ниссан Рено брэндийн бүх төрлийн автомашины иж бүрэн засвар үйлчилгээг чанарын өндөр түвшинд хурдан шуурхай хийн үзүүлж байна.